



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,  
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,  
Улаанбаатар хот, 13381  
Утас/Факс: (976-51) 26 00 62  
Цахим шуудан: info@spa.gov.mn  
Цахим хуудас: www.spa.gov.mn

2023.03.24 № А-1/986  
танай -ны № -т

**Гомдол гарсан тухай**

Тус газраас зарласан ПНШНУГТЭ/202312002/02/01 урилгын дугаартай “П.Н. Шастины нэрэмжит Улсын гуравдугаар төв эмнэлэгт мэс засал ба судсан дотуурх оношилгоо эмчилгээнд хэрэглэгдэх эмнэлгийн хэрэгсэл, протез худалдан авах” төсөл, арга хэмжээний 3, 14, 62 дугаар багцын тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс тендерийн баримт бичгийн талаар гомдол ирүүлсэн байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсэгт “Захиалагч гомдлын агуулгыг бүх тендерт оролцогчид мэдэгдэж, холбогдох шийдвэрээр эрх ашиг нь хөндөгдөж болох тендерт оролцогчийг гомдол барагдуулах ажиллагаанд оролцохыг урина” гэж заасны дагуу гомдол гарсан талаарх мэдээллийг Та бүхэнд хүргэж байна.

Ирүүлсэн гомдлын талаарх мэдээллийг хавсаргав.

Хавсралт:... хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.БАТЗУЛ

132323542

ТХААГ-2023-A4

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ

Захиалагчид гомдол гаргах нь

Төрийн худалдан авах ажиллагааны газар нь “П.Н. Шестины нэрэмжит Улсын гуравдугаар төв эмнэлэгт мэс засал ба судсан дотуурх оношилгоо эмчилгээнд хэрэглэгдэх эмнэлгийн хэрэгсэл, шрөлез худалдан авах” нэртэй, “ПНШНУГТЭ/202312002” дугаартай 32 багцтай тендерийн урилгыг цахим хуудас дээрээ 2023 оны 03 –р сарын 03 өдрийн 18:05 минутад тавьсан байна. Дахин тендерийг ажлын 10 хоногийн хугацаатай буюу 2023 оны 03 сарын 20-ны өдөр нээхээр зарласан байна. Харин “Санчир-Ундрах” ХХК нь уг дахин тендерийн дугаар багцуудад оролцохоор тендерийн бичиг баримт худалдан авсан.

Тендерийн бичиг баримттай танилцаад ТБОНӨМБАҮХАТ хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1-д заасан “Захиалагч нь тендер шалгаруулалттай холбогдуулан хүлээсэн үүргээ зөрчсөн” гэж үзэж, дарваахь багцууд дээр дор дурьдсан үндэслэлээр гомдол гаргаж байна. Үүнд:

Нэг. Нийтлэг зөрчил

1. Захиалагч нь дахин тендерийг ажлын 10 хоногийн хугацаатай зарласан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1-д заасан “Тендерт оролцогч нь энэ хуулийн 11.2-г заасныг зөрчсөн болон тендерийн баримт бичиг бэлтгэх явцад өрсөлдөөнийг хязгаарласан ямар нэгэн зөрчил гарсан гэж үзвэл гомдлоо тендерийн нээлт хийхээс ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт ..... ажлын 5 өдрийн дотор гаргана” гэдгийг зөрчсөн байх ба тендер нь 2023 оны 03 сарын 06-ны өдрөөс 2023 оны 03 сарын 17-ны өдрийг дуустал ажлын 10 хоног байгаа нь “өрсөлдөөнийг хязгаарласан зөрчлийн” талвар тендерт оролцогч гомдол гаргах боломжгүй, гомдол гаргах эрхийг нь шууд хаасан үйл ажиллагаа болсон байх тул захиалагчид гомдол гаргаж байна.

Хоёр. Багц 62-той холбоотой гомдол

2. Багц 62 “Элэгний хавдар бөглөх мэс ажилбарын хэрэгсэл” гэсэн багцийн 5-д судас бөглөгч гэдэг эмнэлгийн хэрэгсэл авахдаа “Microshare Embolization” “Желфон буюу Embolic Agent” гэсэн 2 нэр төрөл бичсэн байх мөртлөө эмнэлгийн хэрэгслийн техникийн тодорхойлолтонд шингэн байхыг шаардсан байна. Энэ нь өөр төрлийн судас бөглөгчийн техникийн тодорхойлолтыг хольж бичсэн гэсэн үг юм. Тухайлбал, Microshare Embolization нь мл-ээр хэмждэг 40 - 700  $\mu$ m

мөхлөгтэй шингэн уусмал ба өөрийн тусгай тариур бүхий судас бөглөгч 2мл шингэнтэй, харин Желфон буюу Embolic Agent нь мг-аар хэмждэг 150-710 мкм мөхлөгтэй хуурай бодис, тариур болон шилэнд 50мг ба100мг-р савлагдсан байдаг.

3. (Microshare Embolization) нь зах зээлд 700,000 төгрөгөөр, (Желфон буюу Embolic Agent) нь зах зээлд 350,000 төгрөгөөр худалдагддаг. (Microshare Embolization)-ийг хэрэглэсэн тохиолдолд урт хугацааны эмчилгээ болно. (Желфон буюу Embolic Agent)-ийг хэрэглэсэн түр зуурын арга хэмжээ болно.
4. Иймд энэ хоёр өөр бүтээгдэхүүнийг холихгүйгээр салгаж өгнө үү, төсөвт өртгийг зөв зохиож өгнө үү гэсэн гомдлыг Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт 2023 оны 01 –р сарын 06 –ны өдрийн 01/14 тоот бичгээр гаргасан ба ШӨХТГ хянаад 2023 оны 01 –р сарын 17 –ны 03-02/96 тоот бичгээр захиалагчийн шийдвэрийг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 19.2-т заасныг зөрчсөн байна гэж шийдвэрлэсэн байдлаар захиалагч огт засаагүй, хуучин хэвээр оруулж ирсэн нь холбогдох хуулийг зөрчөөд байна.
5. Багц 62 “Элэгний хавдар бөглөх мээ ажилбарын хэрэгсэл” гэсэн багцын 3-д “Уян чиглүүлэгч 0,014” гэдэг эмнэлгийн хэрэгслийг худалдан авах төсөвт өртөг буюу нэг бүрийн үнийг 52,920 төгрөгөөр хязгаарласан нь, багцын 4-д “Микрокатетер 2,6-2,8F \* 110см” гэдэг эмнэлгийн хэрэгслийг худалдан авах төсөвт өртөг буюу нэг бүрийн үнийг 716,625 төгрөгөөр хязгаарласан нь тендерт оролцогч нарыг бараа бүтээгдэхүүнийг өөрийн өртгөөс нь доош нийлүүлэх буюу Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-д заасан “ ... бараа бүтээгдэхүүнээ бодит зардлаас доогуур үнээр борлуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчихыг шаардсан байна.
6. Учир нь “Уян чиглүүлэгч 0,014” гэдэг эмнэлгийн хэрэгслийн гаалийн нэгж үнэ нь 60-70 ам. доллар (70\$ x 3540 төг = 247.800 төг) байна. “Микрокатетер 2,6-2,8F \* 110см” гэдэг эмнэлгийн хэрэгслийн гаалийн нэгж үнэ 190 - 1077 ам. доллар ( 190\$ x 3540 төг = 672,600 төг ) байна. (Гаалийн байгууллагын албан ёсны мэдээллийг авч үзнэ үү)

Нэг. Иймд багц 62 дээр ШӨХТГ-ын шийдвэрийг биелүүлж, энэ хоёр бүтээгдэхүүнийг холихгүйгээр салгаж өгнө үү. Техникийн тодорхойлолт болон төсөвт өртгийг бодитой зохиож өгнө үү.

#### Гурав. Багц 3-тай холбоотой гомдол

7. Багц 3 “Захын судасны стент, дагалдах хэрэгсэл” гэсэн багцын 1-д “Захын судасны стент” гэдэг эмнэлгийн хэрэгслийг худалдан авах төсөвт өртөг буюу нэг бүрийн үнийг 1,491,000 төгрөгөөр хязгаарласан нь, багцын 3-д “Чиглүүлэгч 0,018” гэдэг эмнэлгийн хэрэгслийг худалдан авах төсөвт өртөг буюу нэг бүрийн үнийг 92,400 төгрөгөөр хязгаарласан нь, багцын 4-д “Захын судасны тэлэгч” гэдэг эмнэлгийн хэрэгслийг худалдан авах төсөвт өртөг буюу нэг бүрийн үнийг 179,550 төгрөгөөр хязгаарласан нь тендерт оролцогч нарыг бараа бүтээгдэхүүнийг өөрийн өртгөөс нь доош нийлүүлэх буюу Өрсөлдөөний тухай

- хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-д заасан “... бараа бүтээгдэхүүнээ бодит зардлаас доогуур үнээр борлуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчихыг шаардсан байна.
8. Учир нь “Захын судасны стент” гэдэг эмнэлгийн хэрэгслийн гаалийн нэгж үнэ нь 400-440 ам. доллар (440\$ x 3540 төг = 1.557.600 төг) байна. “Чиглүүлэгч 0,018” гэдэг эмнэлгийн хэрэгслийн гаалийн нэгж үнэ 70 ам. доллар ( 70\$ x 3540 төг = 247.800 төг ) байна. “Захын судасны тэлэгч” гэдэг эмнэлгийн хэрэгслийн гаалийн нэгж үнэ 60-70 ам. доллар ( 70\$ x 3540 төг = 247.800 төг ) байна. (Гаалийн байгууллагын албан ёсны мэдээллийг авч үзнэ үү)
9. Эдгээр гаалийн нэгж үнэ дээр тээврийн зардал, гаалийн 5%-ийн татвар, нэмүү өртгийн 10%-ийн албан татварыг нэмэхэд хэд болох вэ? Цаана нь компанийн бусад зардал буюу ажилчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл 24% , агуулахын түрээс, хадгалалт болон дотоод тээврийн зардал, хуулийн үйлчилгээний зардал, валютний ханшны зөрүү, банкны зээлийн хүү гэх мэтийг нэмж тооцвол ... юу болох вэ? Яаж өсөх вэ?
10. Төсөвт өртөг нь зах зээлийн бодит үнээс доогуур байгаа нь тендер шалгаруулалт амжилтгүй явагдах нэг шалтгаан ба хэт хямд үнийн араас хөөцөлдөхөөр үр дагаварт нь гадаад оронд хэрэглэхээ байсан, хэрэглэх зөвшөөрөлгүй, агуулахын хог болсон OUTLET-ын бараа Монголд орж ирэн иргэдийн эрүүл мэндээр тоглодог гашуун түүх давтагдсаар байх болно.
11. Иймд сүүлийн үеийн өндөр технологийн чанартай, аюулгүй эмнэлгийн хэрэгсэл худалдан авахыг хүсэж байвал техникийн тодорхойлолтыг зөв бичих ёстой (Жишээ нь, “Чиглүүлэгч 0,018 \* 260-300см” –ыг техникийн тодорхойлолтоор ялгаж өгөөгүй, оношилгоо зоригуулалттай юу, эмчилгээний зоригуулалттай юу гэдэг нь тодорхойгүй бичигдсэн, гэтэл эдгээр нь хоорондоо үнийн асар өндөр зөрүүтэй байдаг ) ба өндөр технологи шингэсэн чанар, аюулгүй байдлыг дагаж, бараа бүтээгдэхүүний үнэ өртөг бодитой зохиогдох шаардлагатай байна.

Хоёр. Иймд Багц 3 дээр ШӨХТГ-ын шийдвэрийг биелүүлж, техникийн тодорхойлолт болон төсөвт өртгийг бодитой зохиож өгнө үү.

Дөрөв. Багц 14-тэй холбоотой гомдол

12. Багц 14. “Оксигенатор, дагалдах хэрэгсэл” гэсэн багцын техникийн тодорхойлолттой танилцаад уг эмнэлгийн хэрэгслийн техникийн тодорхойлолтыг Улсын 3 –р төв эмнэлгийн удирдлагууд 2022 онд яаж бичиж байсан, 2023 онд хэрхэн өөрчилсөн, эдгээр тодорхойлолтууд олон улсын хэрэглээний стандарттай хэрхэн нийцэж байгааг хүснэгтээр харьцуулав.

№	Бүтээгдэхүүний нэр	Олон улсын хэрэглэх стандарт	2022 оны техникийн тодорхойлолт	2023 оны техникийн тодорхойлолт
1	Хүүхдийн оксигенатор /том/ 25-40кг	Оксигенаторын урсгалын хурд <b>1.5-2.5 л/мин blood flow</b>	Оксигенаторын урсгалын хурд <b>0.5-4.0 л/мин blood flow</b>	Оксигенаторын урсгалын хурд <b>1.0-7.0 л/мин blood flow</b>
2	Хүүхдийн оксигенатор /дунд/ 11-24кг	Оксигенаторын урсгалын хурд <b>1.0-1.8 л/мин blood flow</b>	Оксигенаторын урсгалын хурд <b>2.3-2.8 л/мин blood flow</b>	Оксигенаторын урсгалын хурд <b>0.5-3.5 л/мин blood flow</b>
3	Хүүхдийн оксигенатор /дунд/ 4-10кг	Оксигенаторын урсгалын хурд <b>0.1-1.0 л/мин blood flow –эсвэл нэггүй</b>	Оксигенаторын урсгалын хурд <b>0.1-2.0 л/мин blood flow</b>	Оксигенаторын урсгалын хурд <b>0.1-3.0 л/мин blood flow</b>
4	Оксигенатор том хүний /ультрафильтергүй/	Оксигенаторын урсгалын хурд <b>2.0-7.0 л/мин blood flow</b>	Оксигенаторын урсгалын хурд <b>0.5-0.7 л/мин blood flow</b>	Оксигенаторын урсгалын хурд <b>0.5-0.7 л/мин blood flow</b>
5	Оксигенатор том хүний /ультрафильтертэй/	Оксигенаторын урсгалын хурд <b>2.0-7.0 л/мин blood flow</b>	Оксигенаторын урсгалын хурд <b>0.5-0.7 л/мин blood flow</b>	Оксигенаторын урсгалын хурд <b>0.5-0.7 л/мин blood flow</b>

13. “Оксигенатор” эмнэлгийн хэрэгслийн 2023 оны техникийн тодорхойлолтыг судлан үзэхэд 2022 оны техникийн тодорхойлолтыг үндэслэлгүйгээр өөрчлөн, дордуулж, өөрсдөө хүссэнээрээ янз бүрээр тайлбарлах боломжтой, мэргэжлийн биш хүний толгойг эргүүлэх замаар, тодорхой нэг тендерт оролцогчийг хасах, эсрэгээр тодорхой нэг тендерт оролцогчийг шууд шалгаруулах зорилготой бичиж өөрчлөлт хийсэн техникийн тодорхойлолт байна.

14. Тодруулбал, Багц 14-ын 4 ба 5-д том хүний зүрхийг орлох оксигенаторын урсгалын дээд хурдыг 0.7 л/мин гэсэн нь аймшиг. Энгийнээр хэлбэл, хэрэглээнд том хүний зүрх нэг минутад дээд тал нь 7.0 литр цус шахдаг байхад орлуулан тендерээр авах гэж байгаа нь “Оксигенатор” нь нэг минутад дээд тал нь 0.7 литр

(700 мл) цус эргэлдүүлэх чадалтай байхад болно гэж зааж байгаа нь байж болшгүй зүйл юм.

/ Цус хүний биеийн жингийн 5-9 хувийг эзлэх ба ойролцоогоор 1060 кг/м<sup>3</sup> нягттай, 5-5.5 литр байдаг. Мэдээллийн эх сурвалж: [https://mn.wikipedia.org/wiki/%D0%A6%D1%83%D1%81?fbclid=IwAR3nNfWkgXpW\\_0ioqSxLnqlgszPgdjcyVaCNEoC4YigQm1yJqB7rNRJ2Djo/](https://mn.wikipedia.org/wiki/%D0%A6%D1%83%D1%81?fbclid=IwAR3nNfWkgXpW_0ioqSxLnqlgszPgdjcyVaCNEoC4YigQm1yJqB7rNRJ2Djo/)

15. Мөн Багц 14-ын 3-д заасан 4-10 кг жинтэй хүүхдийн зүрхийг орлуулахдаа оксигенаторын хэрэглээний дээд хүчин чадлыг олон улсад нэг минутад 0,1-1,0 литр гэж заасан байхад манай тендерчид түүнээс хэт дээш буюу 3,0 литр /мин хүчин чадалтай оксигенаторыг шаардаж байгаа нь шалгаруулахаар зорьсноос бусад тендерт оролцогчийг “3.0 л/мин хүчин чадалтай оксигенаторыг санал болгоогүй байна” гэж хасах зорилготой, урьд жилүүдэд тендерээс хасдаг уламжлалт нохой аргаа дахин шинэчлэсэн байна.
16. Мөн Багц 14-ын 1-д заасан 25 - 40 кг жинтэй хүүхдийн зүрхийг орлуулахдаа оксигенаторын хэрэглээний дээд хүчин чадлыг олон улсад нэг минутад 1.5-2.5 литр гэж заасан байхад манай тендерчид түүнээс хэт дээш буюу 7.0 литр /мин хүчин чадалтай оксигенаторыг шаардаж байгаа нь яг дээрхтэй нжил байна.
17. Өөрөөр хэлбэл, Хүний зүрхний ажиглалтыг орлох оксигенаторын үйл ажиллагаа нь хүний нас, хүний биеийн жин, анатоми дээр суурилагдсан, шинжлэх ухааны үндсэн дээр зохион бүтээгдсэн эмчилгээний хэрэгсэл болохоос тендерчдийн “хэнийг шалгаруулах уу хэнийг хасах уу гэдэг” тоглоом наадам, тендерийн луйврын хэрэгсэл биш юм. Энэ бүгдийн цаана дандаа монгол хүний эрүүл мэнд хохирч, аюул эрсдэлд орсоор ирсэн баримтууд илгээр байна.

Гурав. Иймд Багц 14 дээр ШӨХТГ-ын шийдвэрийг биелүүлж, техникийн тодорхойлолтыг мэргэжлийн өндөр түвшинд боловсруулж, тендерийг зөв зохион байгуулж өгнө үү.

5/25